

ЭРТНИЙ ГРЕК, РОМ **НЭМЭЛТ УНШИХ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН**

ЭРТНИЙ ГРЕК БАЙГАЛЬ, ГАЗАРЗҮЙ

Эгийн тэнгис дэх Грекийн баруун, зүүн, өмнөд талд олон тооны арал (1400 орчим) оршдог. Арлуудын нутаг дэвсгэрийн нийт хэмжээ (80000 км²) орчим өчүүхэн бага, энэ нь Хэнтий аймгийн дайтай газар нутаг юм. Грек хадархаг уул ихтэй тул газар тариалан эрхлэхэд таатай биш. Хуурай газраар зорчиход бэрх тул тэнгисээр зорчих нь илүү амар дөт. Олон уул, тэнгис нь Грект нэг эзэнт гүрэн биш, харин өөрийн өвөрмөц соёл, амьдралын хэв маягтай олон тусгаар хот-улс (полис) үүсэх газарзүйн нөхцлийг бүрдүүлжээ.

ХҮМҮҮСИЙН АХУЙ АМЬДРАЛ БА НИЙГЭМ

НТӨ VIII-VI зууны хооронд грекийн хот улсуудын иргэд Газар дундын тэнгис даяар нүүдэллэн, грекийн колони хотуудыг байгуулав. Колоничлол явуулах үндсэн шалтгаан нь тариалангийн үр шимтэй шинэ газар эрж хайх, ашигтай худалдаа наймаа хийх явдал байв. Грекийн хот улсуудаас цэрэг эдийн засгийн хувьд хамгийн хүчирхэг нь Спарт, Афин хоёр байв. Спарт нь цэргийн дэглэм, цөөнхийн засаглалд тулгуурласан бол Афин нь олонхийн засаглал буюу ардчилалд тулгуурлан хөгжиж байв.


Хүснэгт 1 (Спарт, Афин улсуудын ялгаа)

Спарт – цөөнхийн засаглал	Афин олонхийн засаглал
- Спартууд харь улсад дураараа зорчдоггүй - Харийн хүмүүсийг нутагтаа оруулдаггүй. - Хүн амын дийлэнх нь боол. - Хүүхдийг 7 наснаас цэргийн хуаранд хатуу бэрхийг зааж, дуулгавартай тэсвэр хатуужилтай болгон сургадаг - 20-60 нас хүртлээ цэргийн алба хаадаг.	- Афинд маш олон харийнх хүмүүс амьдардаг - Тэд улс төрийн эрх, газар, гэр оронгүй ч худалдаа наймаа эрхэлж, боол эзэмшиж болдог байв. - Хүүхдийг 7 нас хүртэл эх нь өсгөөд дээд давхрагын хөвгүүд сургуульд сурна. - Сургагч боолын хяналтан дор суралцана.

ЭРТНИЙ ГРЕК УЛС ТӨР



НТӨ 500 оны орчим Бага Ази дахь Персийн эзэнт гүрний нөлөөнд орсон грекийн хот улсууд Афины тусламжтайгаар бослого гаргав. Грек, перс хоёр 3 удаагийн дайнаар ширүүн тулалдаж, грекүүдийн ялалтаар төгсжээ. Дайны дараа грекийн саланги тусгай байсан хот улсууд хот улсууд нэгдэж эхлэв.

(Зураг 1. Грек-Персийн дайн)



Афин персийн цэргийн хүчийг дарахад чухал үүрэг гүйцэтгэв. Тиймээс персүүдийн хариу халдлагаас хамгаалахын тулд Афин тэргүүтэй хот-улсууд нэгдэж Делийн холбоог (НТӨ 477) байгуулжээ. Анхандаа цэргийн зорилготой үүссэн Делийн холбоо эцэстээ Афины улс төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэх болов. Афин хотын ноёрхлыг Пелопоннесын холбоог тэргүүлж байсан спартууд эсэргүүцлээ. Ийнхүү Афин, Спарт тэргүүтэй хоёр хүчин өөр хоорондоо ширүүн дайтав. Энэ дайныг Пелопоннесын дайн (НТӨ 431-404) гэдэг. Дайны эцэст Афин хот ялагдсан ч төд удалгүй Спартын хүч ч мөн буурав.

(Зураг 2. Пелопоннесын дайн)



Грекийн хот улсууд дотоод хямралаас болж ийнхүү асар их доройтсоныг ашиглан, умард хөрш Македон улсын Филипп хаан грекийн хот улсуудыг эзлэн авснаар грекийн хот улсуудын эрх чөлөөнд төгсгөл иржээ. Түүнээс арван жилийн дараа Филипп хааны хүү Александр Персийн эзэнт гүрнийг довтлон ялж, цааш Инд мөрөн хүртэл аян дайн хийж агуу их ялалт (НТӨ 325) байгуулав.


(Зураг 3. Македоны Александр)



ЭРТНИЙ ГРЕКИЙН СОЁЛ УРЛАГ

Грекүүд бол хүн төрөлхтөнд соёлын асар их өв үлдээсэн ард түмэн. Олимпийн наадам, драмын жүжиг грекээс гаралтай. Грекүүд бурхдад зориулан бокс, хөнгөн атлетик, бөхийн тэмцээн зохиож наадам хийдэг байснаас олимпийн наадам үүсчээ. Анхны наадам НТӨ 776 онд Олимп ууланд болсон.

(Зураг 4. Олимп)



Олимпод оролцох тамирчид, зохиолч хөгжимчин, гүн ухаантан, улс төрчид, худалдаачид, усан цэргүүд олимп болохоос сарын өмнө Элидаас Олимпийн уул руу 57,7 км замыг маршаар аялж очно. Хөтөлбөр нь тус тусын ажил мэргэжлээр ном хаялцахаас гадна 192,27 метрийн гүйлтээр уралдана. Наадамд оролцогчдыг бүрэн дуугаар алдаршуулан зарлаж, үнэнч шударга оролцох тангараг өргүүлдэг байжээ. Олимп нь бүх Грекийн наадам байсан бөгөөд олимп болох үед овог аймгуудын хооронд дайн самуунтай байсан бол дайнаа зогсоодог байлаа. Тэр үед зөвхөн эрчүүд уралдаан тэмцээнд оролцдог байв. Олимпод оролцогчдоос зөвхөн нэг хүн шалгаруулж “Олимпчин” гэдэг цол олгож, олив модны навчин эрх /хэлхээ/- г Зевс бурхны өмнө ёслол төгөлдөр гардуулдаг байжээ. Хожим Олимпийн наадам Грекийн хэмжээнээс хальж, хүрээгээ тэлэн Хар тэнгис, Эгийн тэнгис, Африкийн хойт хэсэг, Газар дундадын тэнгисийн баруун талыг хамрах болжээ.

Грекчүүд өөрийн гэсэн онцлогтой олон бурхдыг шүтдэг байв. Хот болгон хамгаалагч урхантай, хотын эргэн тойронд бурхдад зориулсан сүм, тахилын газар байжээ. Грекийн бурхад нь хүн төрхтэй байв. Тэдгээр нь хүн шиг бодож сэтгэдэг, хүн шиг зан авир гаргадаг боловч хүнээс илүү хүч чадалтай, мөн үхэлгүй мөнх амьдардаг гэж грекүүд үздэг байжээ. Бурхдын хаан эцгийг Зевс гэдэг.

Жүжиг хамгийн анх Грект үүсчээ. Жүжиг нь эмгэнэлт, инээдмийн гэсэн хоёр үндсэн төрөлтэй байв. Жүжгийг амфитеатр буюу задгай театрт тоглодог байлаа.